



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/277

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.7 дах заалт, Нийслэлийн Өргөө амаржих газар, Австрали Улсын Эпворт эрүүл мэндийн нэгдэл хооронд 2019 оны 5 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан "Харилцан ойлголцлын санамж бичиг"-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 3 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.
2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгох үйл ажиллагааг зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ

091104

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 06 сарын 02-ны өдрийн
А/332 Дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Монгол Улсад ажиллах байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөр лийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Поффам Филлип Андрю Брайн	Австрали Улс	Нийслэлийн Өргөө амаржих газар	Австрали Улсын Элворт эрүүл мэндийн нэгдэл	ГЭ00002296	Мэдээгүйжүү лэг судлал	Эмчлэх	2019.06.11-2019.06.13 /3 хоног/
2.	Rorham Philip Andrew Bryan	Австрали	Нийслэлийн Өргөө амаржих газар	Австрали Улсын Элворт эрүүл мэндийн нэгдэл	ГЭ00002297	Эх барих, эмэгтэйчүүд судлал	Эмчлэх	2019.06.11-2019.06.13 /3 хоног/
3.	Рийдман Эмма Readman Emma	Австрали Улс	Нийслэлийн Өргөө амаржих газар	Австрали Улсын Элворт эрүүл мэндийн нэгдэл	ГЭ00002298	Эх барих, эмэгтэйчүүд судлал	Эмчлэх	2019.06.11-2019.06.13 /3 хоног/